AMBASSADE
DE FRANCE
EN MONGOLIE

Liberté
Égalité
Fraternité

geres
ACTING FOR
CLIMATE
SOLIDARITY

Recommendations to increase access to passives agricultural building solutions for cooperatives in the frame of Financial Scheme for Passives Innovation in Agriculture project, funded by the Solidarity Fund for Innovative Projects of the French Ministry of Europe and Foreign Affairs

Илүү гүнзгий түншлэлийн тусламжтайгаар үнэ цэнийн сүлжээ улам бэхжиж байна. Санхүүгийн байгууллагаас

Geres, Mongolia Office
403 door, 4th floor, Delta office, Juulchin street,1st khoroo, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
mongolia@geres.eu -www.geres.eu

Нөхцөл байдал болон тодорхой саад бэрхшээлийг танилцуулах нь

Хоршоодоос

Үнийн хэлбэлзэл маш өндөр, мөн ямарч баталгаагүй/Зах зээл, нийлүүлэлтийн сүлжээ болон өртгийн сүлжээний сорилтууд

Зах зээл болон бүтээгдэхүүнээ борлуулахад үүсдэг хүндрэл, зах зээлд нэвтрэх боломж, мөн хямд үнэ нь тариалагчдад тулгардаг саад бэрхшээл юм. Зах зээлд нэвтрэх боломж нь алс зайдуу байршил, болон тээвэрлэлтийн хөлстэй холбоотой. Үүнээс үүдэн үнийн талаар тохиролцох хүсэлгүй, бүтээгдхүүний чанарыг хайхардаггүй худалдаачид/зуучлагчдаас ихээхэн хамаарахад хүргэдэг. Жижиг хэмжээний олон тариалагчдид бүтээгдхүүнээ хамгийн хямдаар борлуулдаг нь НЭА хүлэмж, хадгалалт хамгаалаөлт зэрэг технологид хөрөнгө оруулалт хийхэд нь саад болдог гэж тэд үздэг байна. Ханган нийлүүлэлтийн сүлжээний сорилт нь тохиромжгүй тээвэрлэлт болон хадгалалтын төхөөрөмж зэрэг тээвэр зуучлалын хязгаарлалтаас үүддэг. Мөн хоршоод өөрсдийн бүтцийг хамтдаа борлуулахад ашигладаггүй.

Улирлын орлого

Газар тариалангийн олон үйл ажиллагааны адил, хүнсний ногоо тариалагчид улирлын, тогтмол бус орлоготой нь тэдэнд тулгардаг бэрхшээл бөгөөд энэ нь орлогоо баталж, сар тутам тодорхой төлбөр эргэн төлөх асуудлыг хүндрэлтэй болгодог.

Нийтлэг нөхцөл, үүрэг, хариуцлагын тодорхойгүй байдал

Олон хоршоод зээлийн шаардлага, төлбөрийн тухайд өөрсдийн гишүүнчлэлийн нөхцөл, үүрэг, хариуцлагаа сайн ойлгодоггүй. Тэд санхүүгийн аливаа эрсдэлийг хамтран хэрхэн зохицуулах талаар хязгаарлагдмал мэдлэг, туршлагатай. Хоршооны манлайлал, менежментийн тухайд, дарга нар өдөржин сайн дурааараа ажиллаж, хоршоодоо цэцэглэн хөгжүүлэхээр мөнгөгүй зүтгэж байна гэж бодох нь хэтийдсэн хэрэг болно. Нэг хүн хязгаарлагдмал оролцоо, мөнгөний урсгалын тасалдалтай холбоотой эрсдэлийг үүрч, цөөн хэдэн хүний ашиг сонирхолд үйлчилж байна.

Үр дүнтэй манлайлал, менежментийн туршлага байхгүй нь буруу шийдвэр гаргах, стратегийн хязгаарлагдмал чиглэлтэй байх, мөн хоршооны гишүүдддээ туслалцаа үзүүлж чадахгүйд хүргэнэ. Газар тариалангийн идэвхгүй шийдлийн санхүүжилтэд хандалтыг хаадаг хамгийн том үр дагаврууд:

*Хоршооны нэр дээр барьцаа байхгүй

*Орлоготой болж, түүнийгээ хамтдаа батлахад хүндрэлтэй

*Хөрөнгийн хөрөнгө оруулалт авах хамтын хуримтлалгүй

Санхүүгийн байгууллагаас

Жижиг агробизнессийн мэдлэгтэй хүний нөөц байхгүй

Санхүүгийн байгууллагууд жижиг хэмжээний агробизнесст үйлчлэх техникийн мэдлэг, туршлагатай хүний нөөцөөр дутагдалтай. Олон банк хотын болон том хэмжээний уламжлалт үйлчлүүлэгчдээ л мэдэх бөгөөд жижиг аж ахуйтай зээлдэгчдийн сорилтод туслах чадвар тэдэнд байхгүй.

Мөнгөний урсгал, эргэн төлөлтийн хуваарь

Банк, санхүүгийн байгууллага нь газар тариалангийн орлогын улирлын болон тогтворгүй чанарт нийцэхгүй эргэн төлөлтийн хатуу бүтцийг ашигладаг. Энэ үл нийцэл нь жижиг хэмжээний тариалагчдад зээлийн дефолт үүсгэн эргэн төлөлтөд хүндрэл учруулж болно.

ББСБ нь арай уян хатан эргэн төлөдтийн хуваарийг ашигладаг. Зарим нь бүр нөхөн төлөлтийн хязгааргүй хугацааг санал болгодог хэдий ч, өндөр хүүтэй (дунджаар 39%), хугацаа богино байх нь хоршоог санхүүжүүлэхэд хамгийн зөв болно.

Хүсэл сонирхол болон эрсдэл

Санхүүгийн байгууллага нь өндөр эрсдэлээс болоод жижиг агробизнесст дэмжлэг үзүүлдэггүй. Эдгээр эрсдэл нь зах зээлийн хэлбэлзэлтэй үнэ, цаг агаарын урьдчилан таамаглах аргагүй нөхцөл, жижиг хэмжээний фермийн үйл ажиллагааны тогтворгүй байдал юм.

БАНК

Банк нь өөрсдөдөө маш бага эрсдэлтэй зарим зээлийн бүтээгдхүүнээ санал болгодог. Хоршоодыг шаардлага биелүүлдэггүй, зээлийн дефолт үүсгэх магадлалтай, зээл авахын тулд барьцаа болгон тавих ямар нэг өмч хөрөнгөгүй гэж тэд үздэг.

Хангалттай нийт ашиг юмуу ядаж зээлийн үнийн дүнд тэнцэх барьцааг хоршоодоос шаарддаг. Харин СБХэлэлцүүлэг нь:

*Ихэнх хоршоодын цэвэр ашиг 10сая төгрөгөөс доош (34%), (38% нь хариулж чадаагүй), зохих баталгаа хуулга харуулах боломжгүй, орлого нь улирлын чанартайг харуулсан.

*Хоршоодын хувьд гол барьцаа нь газар, тоног төхөөрөмж боловч хоршоодын нэр дээр биш, тоног төхөөрөмж нь маш их элэгдэл хорогдолтой. Ихэнх нь хөрөнгөө барьцаалах өртгөө 10сая төгрөгөөс доош гэж мэдүүлдэг.

ББСБ:

Ихэнхдээ ББСБ нь зээлийн илүү уян хатан шаардлагыг санал болгодог байхад, Lendmn бол үгүй. Гэхдээ ББСБ-н хүү маш өндөр (дунджаар 39%). Бас л орлогоо батлахыг шаарддаг. Хоршоодын хандаж байсан эдгээр байгууллагаас нэг ч хүн СБХэлэлцүүлэгт оролцоогүй.

Ханган нийлүүлэгчидтэй түншилдэггүй

Хэн хэнийхээ бизнессийг дэмжих түншлэл байгуулах санал санаачилга санхүүгийн байгууллага, газар тариалангийн ханган нийлүүлэгчид, болон тариалагчдад дутагдаж байна. Энэ нь жижиг хэмжээний агробизнессийн амжилтад чухал үр, бордоо, тоног төхөөрөмж, худалдан авахад зориулсан зээлийн бүтээгдхүүнийг хөгжүүлтийг хөнгөвчлөх харилцан ашигтай хамтын ажиллагааны боломжийг алдахад хүргэдэг.

СБХэлэлцүүлгийн үед хоршоодын хувьд хамгийн их зардал нь ажиллах хүч, үр бордоо, тоног төхөөрөмж гэдгийг онцолсон. Тэгэхээр хэрэв хоршоод үр бордоондоо дэмжлэг авбал, бусад хөрөнгө оруулалтын зардалд зарим байраа чөлөөлж болох юм.

Жишээ нь, ХААН банканд хүлэмжийн болон үр тариалах хоршоодод зориулсан ямарч санхүүгийн бүтээгдхүүн байхгүй. Гэхдээ, тус банк Газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран газар тариалангийн компаниуд болон хувь хүмүүсийн ажиллах хүч, хөрөнгө оруулалтыг дэмжихээр засгийн газрын татаастай зээлийг (5-6% жилийн хүүтэй, 48 сарын хугацаатай) олгож байна. Хувь хүмүүс энэ зээлийн схемд хандаж болно, харин хоршоод болохгүй.

Эмэгтэйчүүдэд тулгардаг гол хязгаарлалт

Зайлшгүй хэрэгцээтэй тоног төхөөрөмж байхгүй - газар хагалагч, трактор, үр суулгагчийг эмэгтэйчүүд задгай талбайн тариалалтдаа маш өндөр үнэтэй түрээслэх хэрэгтэй болдог. Хүлэмжийн үйлдвэрлэлд газраа хагалахад хүн хүч маш шаардлагатай, байхгүй бол, жижиг хагалагчаар хийдэг. Тээвэрлэлтийн хөлс, ялангуяа том тэрэг иүрээслэх үнэтэй.

Бөөний худалдаачидтай ярилцаж тохиролцдоггүй. (жишээ татах ямар нэг эх сурвалж олвол, бид тавина)

Зөвлөмж нь:

Ханган нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой сорилтыг шийдэхэд энэ бүх сүлжээн дэх оролцогч талуудыан хооронд зохицуулалт, хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай.

Ханган нийлүүлэгч, тариалагчдын хоршоод, татварын байцаагчид болон жижиглэн худалдаалагчдын хооронд, => зах зээлийн эрэлт хэрэгцээ, стандартыг хэрхэн хангах, чанарын гэрчилгээ авахад ханган нийлүүлэгчид хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар тариалагчдын дунд ойлголт дутмаг байгааг арилгах, зах зээлийн хүлээлтийг мэдэх

Тариалачдын хоршоод, үйлдвэрлэгчид, татварын байцаагчид, жижиглэн худалдаалагчид, болон санхүүгийн байгууллагын хооронд => хоршоодын хувьд хамгийн бага орлогыг баталгаажуулж, эргэн төлөлтийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хуваарилах замаар санхүүгийн эрсдэлийг бууруулах. Үнэндээ, хэрэв зуучлагчдын хувьд зарим нэг баталгаа байгаа бол, санхүүгийн байгууллага зээл өгч болно гэдгээ хэлсэн (хамгийн бага хэмжээгээр, хамгийн бага үнээр), хоршоод хөрөнгө оруулж, орлогын зарим баталгаатай болж болно. Гэхдээ, зуучлагчдын хувьд нэмүү өртөг гэж юу болохыг мэдэх хэрэгтэй => чанар тоо хэмжээний даатгал, нэг банкнаасаа хөнгөлөлттэй зээл? + эдгээр оролцогчидтой зөвлөлдсөнөөр хоршоодын бүтээгдхүүний хэмжээ, чанар, өнгө, лабораторийн шинжилгээ, гэрчилгээ, зэрэг зах зээлд юу шаардагддаг талаарх мэдээлэл хомс байгааг арилгахын тулд хэрэглэгчдийн хүсэл сонирхол, хүлээлтийг тодорхойлох. Энэ нь хоршоодын гишүүдийг хамтран борлуулж, хаитран ажиллахад бага зэрэг дэм болно.

Энэ тохиолдолд, төслийн ололт болон бүсад хоршоодын санаачилгаас харахад агуулах бол маш сонирхолтой механизм болоод байгаа юм.

- Нарны зай хураагуурт хүлэмжинд боломжийн дүнгээр хөрөнгө оруулснаар илүү уртасгасан хугацаанд их ургац хураах бөгөөд хавар илүү үнэд хүрэх боломжтой. Гэсэн хэдий ч нийт ашгийн хэмжээ бага (үйл ажиллагааны зардал болон орлогын зөрүү). Бодит нөлөө үзүүлэхийн тулд хоршооны бүх гишүүд нэг хүлэмжтэй байх хэрэгтэй бөгөөд ашиглах аргыг нарийн эзэмшсэн байх шаардлагатай. Эко зоорины хувьд хөрөнгө оруулах зардал 2 дахин өндөр ч нийт ашиг нь үүнийгээ дагаад өндөр (үйл ажиллагааны зардал нь нарны зай хураагуурт хүлэмжтэй төстэй ч ургац авахгүй бүх улиралд өндөр үнээр зарах боломжийг олгоно) бөгөөд ашиглахад нарийн мэдлэг шаардахгүйн сацуу хоршоодын гишүүд дундаа хуваан хэрэглэх боломжтой.
- Африкт илүү хэрэгжиж буй Warrantage (батлан даах тогтолцоо) нь түншлэлд суурилсан үнэ цэнийн сүлжээ бөгөөд энэ нь бүх оролцогч талуудад ашигтай байх үнэ цэнийн сүлжээ бий болгоход саад болж буй голлох хүчин зүйл болж буйг харуулсан. Бид Монгол улсын нөхцөлд ногоо тариалахад аль арга нь илүү тохиромжтой вэ гэдгийг судлах шаардлагатай байна. ХАА-ын Хөгжлийн судалгааны олон улсын хамтын ажиллагааны төвийн адилаар НҮБ-ын Хүнс, ХАА-ын байгууллага[1] нь энэ тогтолцоог "Ногоо тариаланчдын байгууллага болон санхүүгийн байгууллагуудын бий болгосон кредитэд суурилсан хадгалалтын тогтолцоо" гэж тодорхойлсон. Энэ нь тариа хураасны дараа нэг хэсгийг нь агуулахад хадгалан эргээд түүнийгээ хувийн зээл авахад ашиглах боломж юм. Уг кредит байхгүй бол ногоочид өр зээлээ дарах эсвэл хэрэгцээгээ хангахын тулд тариа хурааж дуусмагц түүнийгээ зардаг. Үр дүнд нь ногоочин гэр бүлүүд завсарын үе буюу тариалангүй үеэс шинэ ургац хураах үе хүртэлх шилжилтийн үеийг туулахад хүндрэлтэй байдаг бөгөөд тариалан тарих тогтолцоондоо

[1] https://www.fao.org/in-action/kore/good-practices/good-practices-details/en/c/1103340/

хангалттай хөрөнгө оруулж чаддаггүй. Баруун Буркина Фасод явуулсан нөлөөллийн үнэлгээ нь батлан даах тогтолцоо байснаар завсарын үеийн хоол хүнсний олдоц болон ХАА-ын хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэл нэмэгдэн баталгаажсныг харуулсан. Үүнийг илүү хурдан хөгжүүлэхийн тулд 3 нөхцөл бүрдсэн байх шаардлагатай:

- Дэд бүтэц, барилга байгууламж нь ногоо агуулахад тохиромжтой байх
- Хадгалсан бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах
- Санхүүгийн байгууллага, үйлдвэрлэгч болон худалдаалагч хоорондын ойр бөгөөд итгэлцэлд тулгуурласан харилцааг хангах”[2]

Тариалагчдын ханган нийлүүлэгчид болон санхүүгийн байгууллагын хооронд => дундын эрсдэл бүхий тоног төхөөрөмжид хөрөнгө оруулах баталгааны механизм, төлбөрийн дахин төлөвлөлтийн хуваарьтай байх. Энэ нь ихэнх хоршоодод шаардлагатай тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийж ашигтай бизнесс эрхлэх боломж олгохоос гадна машин техник хэрэгтэй эмэгтэйчүүдэд илүү ашигтай байх болно. Тоног төхөөрөмж нь улирлын бус орлого олох жижиг үйл явц байж болно.

Бизнессийн энэ бүх түншлэл нь жижиг агробизнесст тулгардаг сорилтыг илүү сайн ойлгоход санхүүгийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

Цалингаа нийлүүлсэн хоршооны гишүүд өөрсдийн эзэмшдэг дэд бүтцийн менежмент, ашиглалтыг зохих ёсоор анхаардаг. Тэгснээр хоршооны гишүүдийн хоорондын хүлээлт, хариуцлага нь хамтарсан ажил хийхэд тодорхой болдог.

Энэ зөвлөмж хүйсийн хандлагыг хэрхэн дэмжиж байгаа нь

Тариалагчид, ханган нийлүүлэгчид болон санхүүгийн байгууллагын хооронд бизнесс түншлэл => дундын эрсдэл бүхий тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийхэд баталгааны механизмтай байх, мөн тохируулсан эргэн төлөлтийн хуваариа дахин төлөвлөх. Энэ нь зөвхөн эмэгтэйчүүдийн ажиллуулдаг тоног төхөөрөмжид хамаарна.

[2] Le Cotty T., Maître d’Hôtel E., Porgo I., Soubeyran R., Subervie J., 2023. Le warrantage, un dispositif pour améliorer la sécurité alimentaire en Afrique subsaharienne. Montpellier, Cirad, Perspective 61. https://doi.org/10.19182/perspective/37141

AMBASSADE
DE FRANCE
EN MONGOLIE

Liberté
Égalité
Fraternité

geres
ACTING FOR
CLIMATE
SOLIDARITY

Recommendations to increase access to passives agricultural building solutions for cooperatives in the frame of Financial Scheme for Passives Innovation in Agriculture project, funded by the Solidarity Fund for Innovative Projects of the French Ministry of Europe and Foreign Affairs

Хоёрдогч хоршоодоор дамжуулан санхүүгийн хүртээмжийг дэмжих / NAMAC

Geres, Mongolia Office
403 door, 4th floor, Delta office, Juulchin street,1st khoroo, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
mongolia@geres.eu -www.geres.eu

Нөхцөл байдал болон тодорхой саад бэрхшээлийг танилцуулах нь

Хоршоодоос

Үнийн хэлбэлзэл маш өндөр, мөн ямарч баталгаагүй/Зах зээл, нийлүүлэлтийн сүлжээ болон өртгийн сүлжээний сорилтууд

Зах зээл болон бүтээгдэхүүнээ борлуулахад үүсдэг хүндрэл, зах зээлд нэвтрэх боломж, мөн хямд үнэ нь тариалагчдад тулгардаг саад бэрхшээл юм. Зах зээлд нэвтрэх боломж нь алс зайдуу байршил, болон тээвэрлэлтийн хөлстэй холбоотой. Үүнээс үүдэн үнийн талаар тохиролцох хүсэлгүй, бүтээгдхүүний чанарыг хайхардаггүй худалдаачид/зуучлагчдаас ихээхэн хамаарахад хүргэдэг. Жижиг хэмжээний олон тариалагчдид бүтээгдхүүнээ хамгийн хямдаар борлуулдаг нь НЭА хүлэмж, агуулах зэрэг технологид хөрөнгө оруулалт хийхэд нь саад болдог гэж тэд үздэг байна. Ханган нийлүүлэлтийн сүлжээний сорилт нь тохиромжгүй тээвэрлэлт болон хадгалалтын төхөөрөмж зэрэг тээвэр зуучлалын хязгаарлалтаас үүддэг. Мөн хоршоод өөрсдийн бүтцийг хамтдаа борлуулахад ашигладаггүй.

Улирлын орлого

Газар тариалангийн олон үйл ажиллагааны адил, хүнсний ногоо тариалагчид улирлын, тогтмол бус орлоготой нь тэдэнд тулгардаг бэрхшээл бөгөөд энэ нь орлогоо баталж, сар тутам тодорхой төлбөр эргэн төлөх асуудлыг хүндрэлтэй болгодог.

Нийтлэг нөхцөл, үүрэг, хариуцлагын тодорхойгүй байдал

Олон хоршоод зээлийн шаардлага, төлбөрийн тухайд өөрсдийн гишүүнчлэлийн нөхцөл, үүрэг, хариуцлагаа сайн ойлгодоггүй. Тэд санхүүгийн аливаа эрсдэлийг хамтран хэрхэн зохицуулах талаар хязгаарлагдмал мэдлэг, туршлагатай. Хоршооны манлайлал, менежментийн тухайд, дарга нар нь өдөржин сайн дурааараа ажиллаж, хоршоодоо цэцэглэн хөгжүүлэхээр мөнгөгүй зүтгэж байна гэж бодох нь хэтийдсэн хэрэг болно. Нэг хүн хязгаарлагдмал оролцоо, мөнгөний урсгалын тасалдалтай холбоотой эрсдэлийг үүрч, цөөн хэдэн хүний ашиг сонирхолд үйлчилж байна.

Үр дүнтэй манлайлал, менежментийн туршлага байхгүй нь буруу шийдвэр гаргах, стратегийн хязгаарлагдмал чиглэлтэй байх, мөн хоршооны гишүүдддээ туслалцаа үзүүлж чадахгүйд хүргэнэ. Газар тариалангийн пассив шийдлийн санхүүжилтэд хандалтыг хаадаг хамгийн том үр дагаврууд:

*Хоршооны нэр дээр барьцаа байхгүй

*Орлоготой болж, түүнийгээ хамтдаа батлахад хүндрэлтэй

*Хөрөнгийн хөрөнгө оруулалт авах хамтын хуримтлалгүй

Санхүүгийн бүтээгдхүүний талаар мэдлэггүй

Хоршоодын олон гишүүд зээлийн системийн талаар мэдлэггүй нь зээлийн хүү, эргэн төлөлтин нөхцөл, зээлтэй холбоотой зардал, болон зээлийн менежмент зэрэг санхүүгийн мэдлэг муутайг харуулж байна. Иймэрхүү мэдлэг байхгүйгээс болж тариалагчид нь өөрсдийн санхүүгийн бүтээгдхүүнийхээ хэрэгцээг зөв тодорхойлж, үүнтэй холбоотой эрсдэлийг зохицуулж чадахгүй байна. Энэ нь цаашдаа тэдний агробизнессийн санхүүгийн тогтвортой байдал болон өсөн дэвжихэд сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн, бүх санхүүгийн схемийн дагуу зээл олгохоос өмнө муу зээлийн түүхийг шалгадаг. Тэгэхээр хоршоодын хувьд анхны муу туршлага нь тэдний санхүүгийн бараг бүх боломжийг хааж болох юм. Энэ нь яагаад орлого, зарлагыг бүтээгдхүүний нэр төрөл, зах зээлийн борлуулалтын сувгаар хянадгийг хоршоод ойлгодоггүй, мөн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргаж чадахгүй байна гэсэн үг юм.

Санхүүгийн байгууллагаас

Мөнгөн гүйлгээ, эргэн төлөлтийн хуваарь

Банк, санхүүгийн байгууллага нь газар тариалангийн орлогын улирлын болон тогтворгүй чанарт нийцэхгүй эргэн төлөлтийн хатуу бүтцийг ашигладаг. Энэ үл нийцэл нь жижиг хэмжээний тариалагчдад зээлийн дефолт үүсгэн эргэн төлөлтөд хүндрэл учруулж болно. ББСБ нь арай уян хатан эргэн төлөлтийн хуваарийг ашигладаг. Зарим нь бүр нөхөн төлөлтийн хязгааргүй хугацааг санал болгодог хэдий ч, өндөр хүүтэй (дунджаар 39%), хугацаа богино байх нь хоршоог санхүүжүүлэхэд хамгийн зөв болно.

Хүсэл сонирхол болон эрсдэл

Санхүүгийн байгууллага нь өндөр эрсдэлээс болоод жижиг агробизнесст дэмжлэг үзүүлдэггүй. Эдгээр эрсдэл нь зах зээлийн хэлбэлзэлтэй үнэ, цаг агаарын урьдчилан таамаглах аргагүй нөхцөл, жижиг хэмжээний фермийн үйл ажиллагааны тогтворгүй байдал юм.

БАНК

Банк нь өөрсдөдөө маш бага эрсдэлтэй зарим зээлийн бүтээгдхүүнээ санал болгодог. Хоршоодыг шаардлага биелүүлдэггүй, зээлийн дефолт үүсгэх магадлалтай, зээл авахын тулд барьцаа болгон тавих ямар нэг өмч хөрөнгөгүй гэж тэд үздэг.

БАНК

Банк нь өөрсдөдөө маш бага эрсдэлтэй зарим зээлийн бүтээгдхүүнээ санал болгодог. Хоршоодыг шаардлага биелүүлдэггүй, зээлийн дефолт үүсгэх магадлалтай, зээл авахын тулд барьцаа болгон тавих ямар нэг өмч хөрөнгөгүй гэж тэд үздэг.

Хангалттай нийт ашиг юмуу ядаж зээлийн үнийн дүнд тэнцэх барьцааг хоршоодоос шаарддаг. Харин СБХэлэлцүүлэг нь:

*Ихэнх хоршоодын цэвэр ашиг 10сая төгрөгөөс доош (34%), (38% нь хариулж чадаагүй), зохих баталгаа хуулга харуулах боломжгүй, орлого нь улирлын чанартайг харуулсан.

*Хоршоодын хувьд гол барьцаа нь газар, тоног төхөөрөмж боловч хоршоодын нэр дээр биш, тоног төхөөрөмж нь маш их элэгдэл хорогдолтой. Ихэнх нь хөрөнгөө барьцаалах өртгөө 10сая төгрөгөөс доош гэж мэдүүлдэг.

ББСБ:

Ихэнхдээ ББСБ нь зээлийн илүү уян хатан шаардлагыг санал болгодог байхад, Lendmn бол үгүй. Гэхдээ ББСБ-н хүү маш өндөр (дунджаар 39%). Бас л орлогоо батлахыг шаарддаг. Хоршоодын хандаж байсан эдгээр байгууллагаас нэг ч хүн СБХэлэлцүүлэгт оролцоогүй.

Ханган нийлүүлэгчидтэй түншилдэггүй

Хэн хэнийхээ бизнессийг дэмжих түншлэл байгуулах санал санаачилга санхүүгийн байгууллага, газар тариалангийн ханган нийлүүлэгчид, болон тариалагчдад дутагдаж байна. Энэ нь жижиг хэмжээний агробизнессийн амжилтад чухал үр, бордоо, тоног төхөөрөмж, худалдан авахад зориулсан зээлийн бүтээгдхүүнийг хөгжүүлтийг хөнгөвчлөх харилцан ашигтай хамтын ажиллагааны боломжийг алдахад хүргэдэг.

Жишээ нь, ХААН банканд хүлэмжийн болон үр тариалах хоршоодод зориулсан ямарч санхүүгийн бүтээгдхүүн байхгүй. Гэхдээ, тус банк Газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран газар тариалангийн компаниудын болон хувь хүмүүсийн ажиллах хүч, хөрөнгө оруулалтыг дэмжихээр засгийн газрын татаастай зээлийг (5-6% жилийн хүүтэй, 48 сарын хугацаатай) олгож байна. Хувь хүмүүс энэ зээлийн схемд хандаж болно, харин хоршоод болохгүй.

Засгийн газраас

Чадавхийг бэхжүүлэх сургалт хангалтгүй:

Дээр дурдсан хөдөлгөөний тухайд, хоршоодын гишүүдийн агробизнессийн санал санаачилгыг дэмжсэн зохих сургалт, чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг аймаг сумын захиргаа зэрэг төрийн байгууллагаас боловсруулж, зохион байгуулдаггүй. Зохих боловсролтой байж, ур чадвараа хөгжүүлэлгүйгээр фермер/тариалагчдад нь зээлийг үр ашигтай зарцуулах, зах зээлд нэвтрэх хамгийн сайн туршлагыг олж авах, мөн өөрсдийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад хүндрэлтэй байх болно. Үнэндээ, ЖДҮ-сангаас олгосон зээлийн Сэлэнгэ өгөгдлийн санг харвал, 540-с 334 зээлийг муу зээл гэж тооцож байна. Сэлэнгэ бол газар тариалангийн түүхэн аймаг боловч, энэ сангийн ядаж 10% -г хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулаагүй, 23 хоршоодоос зөвхөн 5 нь СБХэлэлцүүлэгт хандаж сонгогдсон.

Эмэгтэйчүүдэд тулгарч буй гол хязгаарлалт

Зайлшгүй хэрэгцээтэй тоног төхөөрөмж байхгүй - газар хагалагч, трактор, ур суулгагчийг эмэгтэйчүүд задгай талбайн тариалалтдаа маш өндөр үнэтэй түрээслэх хэрэгтэй болдог. Хүлэмжийн үйлдвэрлэлд газраа хагалахад хүн хүч маш шаардлагатай, байхгүй бол, жижиг хагалагчаар хийдэг. Тээвэрлэлтийн хөлс, ялангуяа том тэрэг түрээслэх үнэтэй.

Гэр бүлдээ санаа тавих, хүлэмжийн үйлдвэрлэл болон зах зээлийн тухайд анхаарал хандуулахын хоорондох зөрчил (цагийн хүртээмж).(NAMAC эх сурвалжаас, үзэсгэлэн худалдааны жишээ: ургац хураалтдаа ажиллах тул үзэсгэлэнгийн лангуун дээрээ ажиллаж чаддагүй; NAMAC-н бүлэг эмэгтэйчүүдийн санаачилсан жишээ: нэг нэгнийхээ хүүхдийг ээлжлэн харж ажлаа хийдэг эмэгтэйчүүдийн сүлжээ)

Зөвлөмж нь:

Тоног төхөөрөмж болон пассив шийдэл нь гишүүдийн хувьд хэтэрхий үнэтэй, хоршоодод бол хүртээмжгүй байдаг болохоор нэг шийдэл нь Хоёрдогч хоршоо бөгөөд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авч, пассив шийдлийг бүтээж, тэдгээрээ гишүүдийн хоршоодод түрээсэлдэг. Ингэснээр дараах саад бэрхшээлийг зохицуулдаг:

Зах зээлд нэвтрэх: Хоёрдогч хоршоо нь зуучлагчдаас илүү зах зээлд нэвтрэхэд маш сайн зуучлагч байж чадна.

Улирлын орлого болон мөнгөн гүйлгээний хуваарь эргэн төлөлт: тоног төхөөрөмжийг газар дээр нь түрээсэлж болох ч, НЭА хүлэмж, эко зоорийг жил тутам түрээслэхийн тулд хоршоод улирлын чанартай холбоотой хязгаарлалтыг арилгах мөнгөн гүйлгээтэй, сум өөрийн зээлээ нөхөн төлөх мөнгөн гүйлгээний хуваарьтай бол жил бүр төлбөрөө төлөх боломжтой.

Одоо ажиллаж байгаа ижил бүтцүүдийг харахад санхүүгийн нийтлэг менежментийг бүрдүүлэхэд зарим дэмжлэг шаардлагатай хэвээр байгаа (өмчлөлийн эрх, орлого, хуримтлал) боловч, тодорхой утгаараа шинэ худалдан авалт нь хоёрдогч хоршооны өмч болж, гишүүдэд олгогдох болно.

Үүнд хандахын тулд санхүүгийн өндөр мэдлэг хоршоонд хэрэггүй. Гэхдээ тэд NAMAC-н үйл ажиллагааны гол төв болж, тэдний чадавхийг төлөвшүүлэхийн тулд зах зээл, борлуулалт, санхүүгийн сургалт явуулна. Ингэснээр тэд анхан шатны хоршоодын сургагч болох юм.

Санхүүгийн байгууллагатай харилцахад зуучлагч болох Хоёрдогч хоршоог анхан шатны хоршоог бодвол эрсдэл багатай гэж үздэг. Түүнчлэн хэрэв анхны худалдан авалт хийхдээ олон улсын байгууллага юмуу NAMAC-н дэмжлэг авсан бол эрсдэл багатайд тооцно. Дараагийн худалдан авалтдаа тэд эхнийхийгээ барьцаа болгон ашиглаж болно.

Харин анхаарал хандуулах зүйл бол үгсралт юм. Хүлэмж, агуулахыг буруу загвараар барьсан нь эцэстээ үр дүнтэй, ашигтай ажиллуулах боломжгүйг харуулж байна. Жишээ нь, Мандал сумын агро парк.

Ахин хэлэхэд, эко зоорь нь илүү их боломж байгааг харуулж байна. (зөвлөмжүүдийг харьцуулан харна уу 1)

Энэ зөвлөмж хүйсийн хандлагыг хэрхэн дэмжиж байгаа нь

Энэ нь тоног төхөөрөмжийг хамгийн их хэрэгцээтэй байгаа эмэгтэйчүүдэд илүү хүртээмжтэй болгодог.
Эмэгтэйчүүдийг газар, байшингаа өмчилдөг гэдгийг дурддаггүй нь буурахгүй байгаа ч, газар тариалангийн пассив шийдлийн ашгийг хүртэхэд тэдэнд эдгээр өмч хэрэггүй юм.
Хоёрдогч хоршоо нь анхан шатны хоршоодоос илүү өөр үйлчилгээг, ялангуяа эмэгтэйчүүдэд санал болгох арга зам юм: хүүхэд асрах, эрүүл мэндийн үзлэг (ялангуяа эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг) гэх мэт.

Сум өөрөө нэг төрлийн Агро паркт хөрөнгө оруулалт хийснээр учирч буй саад бэрхшээлийг арилгах хөшүүргийг хэрэгжүүлж болох юм.

AMBASSADE
DE FRANCE
EN MONGOLIE

Liberté
Égalité
Fraternité

geres
ACTING FOR
CLIMATE
SOLIDARITY

Recommendations to increase access to passives agricultural building solutions for cooperatives in the frame of Financial Scheme for Passives Innovation in Agriculture project, funded by the Solidarity Fund for Innovative Projects of the French Ministry of Europe and Foreign Affairs

Ногоо тариаланч хоршоодын засаглал болон бүтцийг малчдын сайн туршлагад суурилан сайжруулах ХХААХҮЯ, ЖДҮ

Geres, Mongolia Office
403 door, 4th floor, Delta office, Juulchin street,1st khoroo, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
mongolia@geres.eu -www.geres.eu

Нөхцөл байдал болон тодорхой саад бэрхшээлийг танилцуулах нь

Хоршоодоос

Үнийн хэлбэлзэл маш өндөр, мөн ямарч баталгаагүй/Зах зээл, нийлүүлэлтийн сүлжээ болон өртгийн сүлжээний сорилтууд

Зах зээл болон бүтээгдэхүүнээ борлуулахад үүсдэг хүндрэл, зах зээлд нэвтрэх боломж, мөн хямд үнэ нь тариалагчдад тулгардаг саад бэрхшээл юм. Зах зээлд нэвтрэх боломж нь алс зайдуу байршил, болон тээвэрлэлтийн хөлстэй холбоотой. Үүнээс үүдэн үнийн талаар тохиролцох хүсэлгүй, бүтээгдхүүний чанарыг хайхардаггүй худалдаачид/зуучлагчдаас ихээхэн хамаарахад хүргэдэг. Жижиг хэмжээний олон тариалагчдид бүтээгдхүүнээ хамгийн хямдаар борлуулдаг нь НЭА хүлэмж, агуулах зэрэг технологид хөрөнгө оруулалт хийхэд нь саад болдог гэж тэд үздэг байна. Ханган нийлүүлэлтийн сүлжээний сорилт нь тохиромжгүй тээвэрлэлт болон хадгалалтын төхөөрөмж зэрэг тээвэр зуучлалын хязгаарлалтаас үүддэг. Мөн хоршоод өөрсдийн бүтцийг хамтдаа борлуулахад ашигладаггүй.

Улирлын орлого

Газар тариалангийн олон үйл ажиллагааны адил, хүнсний ногоо тариалагчид улирлын, тогтмол бус орлоготой нь тэдэнд тулгардаг бэрхшээл бөгөөд энэ нь орлогоо баталж, сар тутам тодорхой төлбөр эргэн төлөх асуудлыг хүндрэлтэй болгодог.

Нийтлэг нөхцөл, үүрэг, хариуцлагын тодорхойгүй байдал

Олон хоршоод зээлийн шаардлага, төлбөрийн тухайд өөрсдийн гишүүнчлэлийн нөхцөл, үүрэг, хариуцлагаа сайн ойлгодоггүй. Тэд санхүүгийн аливаа эрсдэлийг хамтран хэрхэн зохицуулах талаар хязгаарлагдмал мэдлэг, туршлагатай. Хоршооны манлайлал, менежментийн тухайд, дарга нар өдөржин сайн дурааараа ажиллаж, хоршоодоо цэцэглэн хөгжүүлэхээр мөнгөгүй зүтгэж байна гэж бодох нь хэтийдсэн хэрэг болно. Нэг хүн хязгаарлагдмал оролцоо, мөнгөн гүйлгээний тасалдалтай холбоотой эрсдэлийг үүрч, цөөн хэдэн хүний ашиг сонирхолд үйлчилж байна. Үр дүнтэй манлайлал, менежментийн туршлага байхгүй нь буруу шийдвэр гаргах, стратегийн хязгаарлагдмал чиглэлтэй байх, мөн хоршооны гишүүдддээ туслалцаа үзүүлж чадахгүйд хүргэнэ. Газар тариалангийн пассив шийдлийн санхүүжилтэд хандалтыг хаадаг хамгийн том үр дагаврууд:

* Хоршооны нэр дээр барьцаа байхгүй
*Орлоготой болж, түүнийгээ хамтдаа батлахад хүндрэлтэй
*Хөрөнгийн хөрөнгө оруулалт авах хамтын хуримтлалгүй

Төрийн байгууллагаас

Хамтын хөдөлгөгч хүчний бэрхшээл болон сорилтыг дутуу үнэлэх

Засгийн газар газар тариалангийн хоршоодын хэрэгцээ болон сорилтын талаар бүрэн ойлголт авалгүйгээр бодлого хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ байдлаас болж хоршоодод тулгардаг бодит асуудлыг шийдэж чадахааргүй тохирохгүй нөөц бололцоогоор хангах, зохисгүй тусламж үзүүлэхэд хүргэдэг.

Жишээ нь, малтай болох, мөн малын бус түүхий эд материалын өртгийн сүлжээ болон худалдаатай болж өсөн дэвжихэд нь туслахаар МУ-ын ЗГ “Шинэ хоршоо” (2024-2029) хөнгөлөлттэй зээлийн схемийг 2024оны 5 сард эхлүүлсэн. "Шинэ хоршоо – өсөн дэвжиж буй малчин" үндэсний хөдөлгөөн нь Монголын төв банк болон арилжааны 7 банкаар дамжуулан 6% хүүтэй зээлийг хоршооны гишүүд-малчдад олгохоор 5 тэрбум төгрөгийг төсөвлөсөн нь ЗГ-с дэмжсэн баталгааны тогтолцоо бүхий концессын зээл юм. Энэ нь хүнсний ногоо тариалагчдыг өргөжүүлэх цаасан дээрх сайхан санаачилга боловч, зөвхөн шинэ хоршоодод зориулсан, тэдгээрийн гишүүдийн нэр дээр олгогдоно. Удаан оршин

тогтносон хоршоод санхүүгээ хамтран удирдахад хүндрэлтэй байдгийг бид мэднэ, гэхдээ энэ нь маш аюултай арга шиг санагддаг.
Өөр нэг жишээ бол MoFALI -н арилжааны банкаар дамжуулсан татаасын хүүтэй концессын (16%-ийн оронд 6%) зээл бөгөөд 5000сая төгрөг хүртэл хэмжээтэй, 10 жилийн хугацаанд эргэн төлөх зээл юм. Эдгээр зээл нь хэрэгцээнд маш сайн нийцэж байгаа боловч, банкны шаардлага хангахгүй хүнсний ногоо тариалагчдын хоршоодод хүртэхгүй юм.
ЖДҮ-н сангууд, хоршоо хөгжүүлэх сангууд нь хүнсний ногоо тариалагчдын хоршоодод илүү тохирч байгаа юм. Үнэндээ, тавигдах шаардлага (ялангуяа барьцаа), тийм ч чухал бус, харин маш өндөр буурах хүүтэй (3%) зээлийн хэмжээ (2 500сая төгрөг хүртэл) чухал юм. Энд зээлийн эргэн төлөлтийн хугацаа харьцангуй богино (5жил). Энэ механизм нь тоног төхөөрөмж гэх мэт жижиг хөрөнгө оруулалтад тохирох боловч, НЭА байгууламж зэрэгт тохирохгүй. Үнэндээ:
Олгосон ихэнх зээл 10сая төгрөгөөс дээш байна (жишээ нь, Сэлэнгэ өгөгдлийн санд, 2011оноос хойш ЖДҮ-т олгосон 540зээлээс 369 зээл нь 10саяас дээш байна).
Газар тариалангийн пассив шийдэл нь том хэмжээний хөрөнгө оруулалтаас татгалздаг (НЭА хүлэмжийг өөрсдөө барихад 25 сая төгрөгөөс эхлээд эко зоорийг компани барихад 100сая төгрөг хүртэл), энд нийт ашиг нь НЭА хүлэмжид авсан зээлээ богино хугацаанд нөхөн төлөхөд хангалтгүй юм (жил тутам нэмээд 6 сая төгрөг).

Эмэгтэйчүүдэд тулгарч буй гол хязгаарлалт

Зайлшгүй хэрэгцээтэй тоног төхөөрөмж байхгүй - газар хагалагч, трактор, үр суулгагчийг эмэгтэйчүүд задгай талбайн тариалалтдаа маш өндөр үнэтэй түрээслэх хэрэгтэй болдог. Хүлэмжийн үйлдвэрлэлд газраа хагалахад хүн хүч маш шаардлагатай, байхгүй бол, жижиг хагалагчаар хийдэг. Тээвэрлэлтийн хөлс, ялангуяа том тэрэг түрээслэх үнэтэй.
Өмчлөлийн эрх – Байр юмуу газрын өмчлөлийн эрхийн гэрчилгээ ихэнхдээ өрхийн тэргүүн буюу нөхрийн нэр дээр байдаг учраас барьцаатай холбоотойгоор эмэгтэйчүүдэд бас нэг бэрхшээл тулгардаг. Энэ тэднийг барьцаа бага шаарддаг ББСБ-руу хандахад хүргэдэг. Гэхдээ ББСБ-н хүү өндөр. Мөн эмэгтэйчүүд өөрийн нэр дээр банкны дансгүй байдаг.
Гэр бүлдээ санаа тавих, хүлэмжийн үйлдвэрлэл болон зах зээлийн тухайд анхаарал хандуулахын хоорондох зөрчил (цагийн хүртээмж).(NAMAC эх сурвалжаас, үзэсгэлэн худалдааны жишээ: ургац хураалтдаа ажиллах тул үзэсгэлэнгийн лангуун дээрээ ажиллаж чаддаггүй; NAMAC-н бүлэг эмэгтэйчүүдийн санаачилсан жишээ: нэг нэгнийхээ хүүхдийг ээлжлэн харж ажлаа хийдэг эмэгтэйчүүдийн сүлжээ)

Зөвлөмж нь:

Хэдий өөр ч, малчид, хүнсний ногоо тариалагчдын хоршоод нь хоршоогоо байгуулж зүй зохистой ажиллуулах тухайд нийтлэг сорилттой тулгардаг.

Түүхэн уламжлалаараа нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг Монгол улсад малчдад зориулсан санал санаачилга түлхүү байдаг. Малчдын туршлага нь хүнсний ногоо тариалагчдын секторт ч гэсэн ашигтай байж болно.

Нэг жишээ нь №187 тогтоолыг амьдралд хэрэгжүүлэн статусаа шинэчилсэн Хүнсний ногоо тариалагчдын хоршооны хувьд уламжлалт мал аж ахуйг эрхлэхэд үүр амьсгалын нөлөөг бууруулах хуульд нийцүүлэн мал аж ахуйн хоршоонд газар олгох (5 га) юм.

Үнэндээ хоршооны хувьд хөрөнгө оруулалтын нэг чухал зардлаа хасахад хүнсний ногоо тариалагчдын хоршоонд 5 га газар олгож байгаа нь ирээдүйд санхүүгийн схемд хандахад хоршооны нэр дээр барьцаа хөрөнгөтэй болох боломж юм.

Гэхдээ бидний харснаар, хоршооны статуст хоршооны дундын санхүүгийн тал дээр тавигдах шаардлага, зохицуулалт, өмчлөлийн эрх, хамгийн бага хэмжээний дэнчин зэрэг багтдгийг үл харгалзан, үүрэг хариуцлагын тодорхойгүй байдлыг аажмаар арилган дээр дурдсан эдгээр нөхцлийг хянан үзэх зайлшгүй шаардлагатай. Үүнд:

Барьцаа хөрөнгөтэй, орлогын мэдүүлэгтэй, санхүүгийн хүртээмж сайтай хоршоодын нэр дээр хадгаламжтай байх, зохион байгуулалтын нийтлэг бүтэцтэй, хамтын хөдөлгөгч хүчтэй байх.

Ингэснээр доорх зүйлд нөлөөлнө:

Зах зээлд нэвтрэх боломж => хоршоод зуучлагчидтай илүү сайн харилцана, эсвэл шууд худалдааны нийтлэг дэлгүүртэй болно.

Улирлын орлого => хэрэв хадгалалтын дундын байгууламжтай бол, тэд жилээс жилд борлуулалтаа хийх болно. Хэрэв тэд нийтлэг хадгаламжтай бол, жилээс жилд тогтмол борлуулалт хийхээр жижиг машин техникээ өөрчлөх зарим хөрөнгө оруулалт хийж болно.

Цэвэр ашиг өснө: худалдан авалтын зардал (үр, баглаа боодол) тээвэр зуучлалын зардлыг бууруулан, илүү үнээр илүү борлуулалт хийснээр ашиг өснө.

Малчдын хоршоотой харьцуулахад, хүнсний ногоо тариалагчдын хоршоо чадавхаа дутуу ашиглаж байна. Мэдээж, малчдын хувьд, ялангуяа ноолуураас үүдсэн хэрэгцээ шаардлага, нэмүү өртөг нь ноолуураа ченжүүдэд борлуулахад хүргэж байна.

MoFALI -гаас онцлох ёстой малчдын хоршооны, мөн хүнсний ногоо тариалагчдын хоршооны амжилт нь нэмүү өртөг гэж юу болох, бүрэн ашиглавал хоршооны хүч чадал ямар байдгийг харуулж байна.

Энэ зөвлөмж хүйсийн хандлагыг хэрхэн дэмжиж байгаа нь

Санхүүгийн хүртээмж сайжирч, үүрэг хариуцлагаа хуваалцах нь бэрхшээлийг даван туулахад эмэгтэйчүүдэд маш чухал: тэд шаардлагатай тоног төхөөрөмж авах боломжтой болно. Энд өөрийн нэр ямар нэг өмчтэй байх шаардлагагүй бөгөөд ажил үүргээ хуваарилвал зөрчилдөх цаг гарахгүй.